БАТЛАВ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ТАМИР

2025 оны .... сарын .... өдөр

ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГААНЫ (1-24 ДҮГЭЭР ХОРОО)
АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 08 дугаар сарын 25 Дугаар..17 Улаанбаатар хот

1.	Судалгааны ажил гүйцэтгэх үндэслэл	- Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Дүүргийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 16 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт
2.	Байршил	Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороо
3.	Зорилго	Хороодын нутаг дэвсгэр дэх дэд бүтцийн хүртээмжийг тодорхойлох, түүнд үндэслэн сайжруулах санал боловсруулах
4.	Хамрах хүрээ	Чингэлтэй дүүргийн хэмжээнд физик дэд, нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламжийн хүртээмжийг тодорхойлох. Эдгээрийг хүртээмжтэй болгох үүднээс хаана, юуг, хэдийг нэмж төлөвлөх шаардлагатай талаар зөвлөмж, дүгнэлт гаргах.
5.	Хийх ажил	Физик дэд бүтэц - Дүүргийн нутаг дэвсгэр дэх авто зам, дугуйн зам, явган хүний замын байршил, уртыг тодорхойлох - Төлбөртэй болон төлбөргүй авто зогсоолын байршлын тоог гаргах, тэдгээрийн багтаамжийг тодорхойлох - Автобусны зогсоолын тоог хороо бүрээр гаргах, эцсийн зогсоолоос цааш суурьшлын хэсгийн зах хүртэл зайг тогтоох - Цахилгаанд холбогдоогүй өрхийн тоо, байршлын тогтоох - Ус түгээх цэгийг /худаг/ хороо бүрээр гаргах - Ашиглалтад байгаа уурын зуухны байршлыг тодорхойлох - Сэдэвчилсэн зураг бэлдэх (ArcGIS, QGIS гэх мэт газарзүйн мэдээллийн системийн программд) Нийгмийн дэд бүтэц - Хороо тус бүрийн хүн ам, нас, хүйсийн тоог гаргах - Сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, хорооны цогцолбор барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх зориулалтын налуу зам, хаалганы бариулын стандарт өндөр, хараагүй хүмүүст зориулсан брайл үсэг бүхий бариул, мэдээллийн самбар байгаа эсэх, гадна орчны тохижилт стандартын дагуу эсэхийг тодорхойлох - Сургуулийн суудлын тоо харьяа хамрагдах ёстой хүүхдийн тоог хангаж байгаа эсэх, БНбД-д заасан радиуст байрлаж байгаа эсэх, радиуст багтахгүй амьдарч буй өрхийн болон хүүхдийн тоог гаргах, сургуулийн цэвэр, бохир, дулааны эх үүсвэрийг тодорхойлох

		- Цэцэрлэгийн орны тоо харьяа хамрагдах ёстой хүүхдийн тоог хангаж байгаа эсэх, БНбД-д заасан радиуст байрлаж байгаа эсэх, радиуст багтахгүй амьдарч буй өрхийн болон хүүхдийн тоог гаргах, цэцэрлэгийн цэвэр, бохир, дулааны эх үүсвэрийг тодорхойлох - Хүүхдийн сувиллын байршил, орны тоо, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох - Асрамжийн газрын байршил, орны тоо, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох - Номын сангийн байршил, суудлын тоо, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох - Сэдэвчилсэн зураг бэлдэх (ArcGIS, QGIS гэх мэт газарзүйн мэдээллийн системийн программд) Ногоон байгууламж - Иргэдийн амарч суух зориулалт бүхий нийтийн эзэмшлийн талбай, цэцэрлэгийн ногоон байгууламжийн эзлэх хэмжээ, мод, бут, сөөг, зүлгийн хэмжээг гаргах, тэдгээрийг хүн амын тоотой харьцуулж нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг тогтоох - Сэдэвчилсэн зураг бэлдэх (ArcGIS, QGIS гэх мэт газарзүйн мэдээллийн системийн программд)
6.	Судалгааны аргачлал	- Судалгааг хамрах хүрээтэй уялдуулан тохиромжтой арга, аргачлалыг ашиглан, судалгааны үе шатыг бүрэн тодорхойлсон талаарх мэдээллийг агуулсан байна. - Мэргэжлийн судлаачдын дүгнэлтэд үндэслэн хороо, СӨХ, оршин суугч, иргэдийн оролцоотой судалгааг гүйцэтгэж баримтжуулсан байна. - Судалгааны объект бүрийн байршлыг тодорхойлж, орон зайн мэдээ үүсгэн, shapefile /*.shp/, geodatabase /*.gdb/ форматаар өгнө. Судалгааны объектуудыг нэгтгэж, нэг сэдэвчилсэн зураг бэлдэж өгнө.
7.	Судалгааны ажлын чиглэл	- Судалгааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, захиалагч байгууллагаас санал авч батлуулах - Судалгааны явцад эх сурвалжийг тогтмол бүрдүүлэх - Судалгааны анхдагч материалуудыг баримтжуулах - Судалгаанд цуглуулсан мэдээллийг боловсруулж, нэгдсэн үр дүнгийн тайлан, санал зөвлөмжийг захиалагчид танилцуулах, хүлээлгэн өгөх - Бусад шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх
8.	Судалгааны үр дүн	- Судалгаа хийснээр гарсан үр дүнг тодорхойлох - Стандарт, норм дүрэмд нийцүүлэх, сайжруулах санал, зөвлөмж, дүгнэлт, шийдлийг гаргах
9.	Судалгааны дүгнэлт	Судалгааны ажлын үр дүнгийн талаар тодорхой үнэлгээ өгсөн байх.
10.	Ашигласан материалын жагсаалт	- Судалгааны ажилд ашиглагдсан материалуудыг зохих стандартын дагуу бичиж тэмдэглэсэн байна.
11.	Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног
12.	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага: - Монгол улсад бүртгэлтэй зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх - Судалгаа, шинжилгээ, болон баримт бичиг бололвсруулж байсан туршлагатай байх

		- Хот төлөвлөлтийн архитектор, геодезийн инженер, авто замын инженер, статистикч мэргэжилтэй инженер техникийн ажилтантай байх Бусад шаардлага: - Судлаачдын бүрэлдэхүүн 3-аас доошгүй гишүүнтэй байх - Дүн шинжилгээ хийх - Харьцуулсан судалгаа хийх
13.	Тайлангийн хуваарь	- Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш 14 хоног тутам ажлын явц, үр дүнг тайлагнана. - Ажил эхэлснээс хойш 30 хоногийн дотор эхлэлийн тайланг ирүүлнэ. Эхлэлийн тайланд газар дээр ажиллаж, байршил, бүртгэл, мэдээллийг цуглуулан тэдгээрт хийсэн дүн шинжилгээг танилцуулсан байна. - Эхлэлийн тайланг ирүүлснээс хойш 30 хоногийн дотор эцсийн тайланг ирүүлнэ. Захиалагчаас эхлэлийн тайланд өгсөн санал, шүүмжийг тусгасан байна. Эхлэлийн тайланд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах санал, үндэслэл бүхий төлөвлөлтийг хийсэн байна.
14.	Судалгааны ажилд тавигдах шаардлага	- Тайлан нь монгол хэл дээр бичигдсэн байна. - MNS 5140-2:2021 Баримт бичиг. 2-р хэсэг: Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага стандартыг баримталсан байна. - Хэл найруулга зөв, оновчтой байна. - Монгол хэлний зөв бичих дүрмийн болон утга найруулгын алдаагүй байна. - Ажлын даалгаврын дагуу боловсруулсан судалгааны тайлан, төлөвлөлтийн шийдэл, санал, зөвлөмж, дүгнэлтийг боловсруулсан байна. - Тайланд оруулах төлөвлөлтийн болон сэдэвчилсэн зураг нь нягтрал, чанарын өндөр түвшинд байна. - Тайланг 3 хувь хийж, цаасан болон цахим хувийг CD хуулж ирүүлнэ. (Ажлын файлыг *.dwg, *.psd, *.shp, *.gdb гэх мэт өөрсдийн ажилласан программын форматаар ирүүлэх)

ХЯНАСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга М.Цогтбилэг

БОЛОВСРУУЛСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Батцэцэг